



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **Соёл Урлагийн Их Сургууль**

Хөтөлбөрийн нэр: **“Маркетинг” бакалаврын хөтөлбөр**

Индекс: **D041401**

Шинжээчийн баг:

Ахлагч: **О.Бурмаа** /Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн Бизнес удирдлагын тэнхимийн дэд профессор, доктор/

Гишүүд: **Л.Отгонцэцэг** /Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Бизнес удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн зөвлөх профессор, доктор/

И.Баярсайхан /“Доктор авто сүлжээ” ХХК-ийн Франчайз салбар хариуцсан супервайзер

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АНУ – Америкийн Нэгдсэн Улс

БНХАУ – Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БМИҮЗ – Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл

БШУ – Боловсрол Шинжлэх Ухаан

ЗГ – Засгийн Газар

МУИС – Монгол Улсын Их Сургууль

ОЗ – Оюутны Зөвлөл

СУИС – Соёл Урлагийн Их Сургууль

СҮТ – Соёлын Үйлдвэрлэлийн Тэнхим

ХААИС – Хөдөө Аж Ахуйн Их Сургууль

ШУТИС – Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль

ЭЕШ – Элсэлтийн Ерөнхий Шалгалт

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Соёл Урлагийн Их Сургууль Mongolian State University of Arts and Culture	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	“Маркетинг” “Marketing”	
Индекс	D041401	
Шинжээчид	1. О.Бурмаа Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн Бизнес удирдлагын тэнхимийн дэд профессор, доктор 2. Л.Отгонцэцэг Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Бизнес удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн зөвлөх профессор, доктор 3. И.Баярсайхан “Доктор авто сүлжээ” ХХК-ийн Франчайз салбар хариуцсан супервайзер	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Г.Даваажаргал Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн, доктор	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2022.05.25	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2022.06.02-03	СУИС-ийн Соёлын Сургууль дээр очиж шинжээчид ажилласан.
	2022.06.10	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

СУИС-ийн “Соёлын сургууль”-ийн “Маркетинг” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Соёлын үйлдвэрлэлийн тэнхим нь 1990 онд Нийгмийн ухааны тэнхим нэртэйгээр байгуулагдаж, өдгөө 30 гаруй жилийн түүхтэй туршлагатай тэнхим юм. Бакалаврын түвшинд 2012 оноос “Соёл урлагын маркетинг” (D340504), 2014 оноос “Маркетинг” хөтөлбөрөөр сургалт явуулж, 2018 болон 2020 онуудад хөтөлбөрийг дахин шинэчилсэн.

2020 онд шинэчлэн боловсруулсан “Маркетинг” хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг дараах байдлаар тодорхойлсон.

- Нийгэм хүмүүнлэгийн суурь мэдлэг эзэмших, соёл, урлагийн салбарын суурь ойлголтуудыг тайлбарлах (explaining)
- Соёл, урлагийн болон бусад салбарын зах зээлийн онцлог, хөгжлийн өнөөгийн байдлыг судлах, үнэлэх, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох (Evaluating)
- Салбарын зах зээлийг чиг хандлагатай уялдуулан маркетингийн бодлого стратегийг төлөвлөн хэрэгжүүлэх (Applying)
- Соёлын онол, урлагийн түүх, соёлын өв, соёлын боловсрол, гоо зүйн суурь мэдлэгээ ашиглан гарааны бизнесийг хөгжүүлэх (Developing)
- Мэдээллийн технологи, гадаад эх сурвалжийг ашиглах, мэдээлэлд дүн шинжилгээ хийж шүүн тунгаах (analysing)
- Судалгаа, шинжилгээний үр дүнд тулгуурлан тайлан боловсруулах, тайлагнах (analysing, applying)
- Мэргэжлийн хүрээнд англи болон бусад хэлээр мэдээлэл хайх, дүгнэх, харилцах (demonstrate)
- Авьяас сонирхлоосоо хамааран урлагийн тодорхой төрлүүдээс суралцан, мэргэжлийн үйл ажиллагаандаа ашиглах (implementing)
- Асуудал шийдвэрлэх, багаар ажиллах, харилцааны ур чадвартай, мэргэжлийн ёс зүйтэй, бүтээлч сэтгэлгээтэй, тасралтгүй хөгжих дадал эзэмшсэн менежер болохоо харуулах
- Үндэсний соёлын онцлог, үнэт зүйлсийг хадгалах, түгээн дэлгэрүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах
- Маркетингийн орчин үеийн чиг хандлага, техник технологийн арга хэрэгслийг ашиглан агуулга бүтээх, хүргэх (producing)
- Соёл, урлагийн болон бусад байгууллагын маркетингийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх (creating, implementing)

“Маркетинг” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө нь БШУ-ны сайдын 2014 оны А174 дүгээр тушаалын дагуу “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу хийгдсэн.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон Улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Маркетинг мэргэжлийн хөтөлбөрийг СУИС болон Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэнхимийн сургалтын туршлага, Монгол Улсын хууль тогтоомж, СУИС-ийн эрхэм зорилго, дүрэм, журмын хүрээнд үндэслэн боловсруулсан.
- Маркетинг хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахдаа гадаад Улсын сургуулиудаас АНУ-ын San Diego их сургууль, Southern их сургууль, БНСУ-ын Nanjang их сургууль, дотоодын их сургуулиас МУИС, СЭЗИС, ШУТИС, ХААИС-ийн “Маркетинг” хөтөлбөрийн агуулга, хичээллэх үйл явц, сургалтын орчин, дадлага, уран бүтээл, багшийн ур чадвар, оюутны хөгжил зэргийг судалж, харьцуулалт хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн соёл, урлагийн байгууллагад ажиллах “Маркетинг” мэргэжлээр төгсөгчдийн мэргэжлийн хэрэгцээ шаардлагын судалгааг гаргаж, хөтөлбөрт STEEP шинжилгээ хийсэн.
- Маркетингийн шинжлэх ухааны орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн олон улсад туршлага болж буй соёлын салбарын онцлогийг тодорхойлсон шинэ хичээлүүдийг нэмж оруулсан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход оролцогч болон сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх олон ажлууд өрнүүлж байгаа ч санал, зөвлөмжүүдийг баталгаажуулах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахдаа гадаад, дотоодын их сургуулиудын хөтөлбөртэй агуулгын хүрээнд харьцуулсан судалгаа хийх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн загвартай.

- Хөтөлбөрийн зорилгыг үндэсний болон салбарын хэмжээний төрийн бодлоготой уялдуулсан, сургуулийн эрхэм зорилготой холбосон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилгыг суралцагчдын эзэмших боловсролын хэрэгцээ, хөдөлмөрлөх хэрэгцээ, амьдралын хэрэгцээ, нийгмийн хэрэгцээг уялдуулсан агуулгатай байхаар тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- СУИС-ийн “Маркетинг” хөтөлбөрийн бусад ижил төрлийн хөтөлбөрөөс ялгагдах онцлогийг хөтөлбөрийн зорилго дээр илүү тодорхой харьцуулж харуулах
- Хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэхэд оролцогч талуудаас авч буй олон төрлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгааг баталгаажуулах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зорилгыг дахин тодорхойлохдоо мэргэжилтэн бэлтгэх талаас нь боловсруулах;
- Хөтөлбөрийн зорилтыг зөвхөн мэдлэг, ур чадвараар тодорхойлж, хандлага төлөвшил эзэмшүүлэх чиглэлийг орхигдуулсаныг засварлах;

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- “Маркетинг” хөтөлбөрийг 2014, 2018 болон 2020 онуудад шинэчлэн боловсруулсан.
- Сургалтын төлөвлөгөөн дэх хичээл хоорондын холбоосыг гаргасан.
- Шинэчлэн сайжруулсан хөтөлбөр нь баримт бичгийн хүрээнд сайтар боловсруулагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол Улсын хөгжлийн бодлогод соёлын бүтээлч үйлдвэрлэл нь эдийн засгийн салбарын чиглэлд байгаа нь энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах боломжтой.
- Сургалтын үр дүнд суралцагч эзэмшин төгсөх цогц чадамжийг тодорхойлсон “Маркетинг” хөтөлбөрийн зорилго (PEO), хөтөлбөр (PLO), хичээлийн (CLO) суралцахуйн үр дүнгийн матрицыг боловсруулсан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр суралцагчдад олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч болон сонирхогч талуудын судалгааг тэнхимийн хүрээнд 2 жил дараалан хийсэн боловч эдгээр судалгааны үр дүнг хөтөлбөрийн хороо болон тэнхимийн хурлын протоколоор баримтжуулаагүйг цаашид анхаарах

- Зарим мэргэшүүлэх болон мэргэжлийн хичээлийн суралцахуйн үр дүнг (CLO) дахин шинэчлэхдээ төгсөгч болон ажил олгогчдын оролцоог нарийвчлан тусгах

Зөвлөмж:

- Оролцогч болон сонирхогч талуудын судалгааг нэгдсэн арга зүйгээр боловсруулж, тогтмолжуулах

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний шинэчлэлийг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, СУИС-ийн дүрэм, журмын хүрээнд үндэслэн боловсруулсан.
- “Маркетинг” мэргэжлийн тодорхойлолтод онолын мэдлэг олгохоос гадна практик мэдлэг, ур чадварыг олгох зорилготой танилцах болон мэргэжлийн дадлага зэргийг оруулсан ба энэ нь бие даасан хичээлийн хэлбэртэй, тооцох кредиттэйгээр тусгагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- БШУЯ-ны баримталж буй бодлого, сургуулийн стратеги, эрхэм зорилготой уялдуулан 2012 онд Соёл, урлагийн маркетинг (D041401), 1998 онд Маркетинг (D041401), 2020 онд Маркетинг (D041401) мэргэшүүлэх чиглэлүүд болох (Реклам, зар сурталчилгаа), (Олон нийттэй харилцах), (Соёлын Худалдаа) тус тус сайжруулан шинэчилж ирсэн.
- Сургалтын Uniculture мэдээллийн системтэй.
- Хичээл хоорондын залгамж холбоотой.
- БШУ-ны сайдын А/348 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, дүйцүүлэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах үлгэрчилсэн журам”-ын дагуу сургалтын хөтөлбөрөө шинэчлэн баталсан.
- “Маркетинг” хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний шинэчлэлтүүд тасралтгүй сайжирсаар байна.
- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр нь онол, практикийн зохистой харьцааг хангасан.

Анхаарах асуудал:

- Дотоодын бусад хөтөлбөрөөс ялгарах онцлог талууд байгаа боловч хөтөлбөрт тусгагдсан байдал нь бодит байдлаасаа дутагдалтай байгааг анхаарах
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг зөвхөн мэдлэг, ур чадвараар (ерөнхий, мэргэжлийн) гаргасан байгааг шинэчлэн сайжруулах

Зөвлөмж:

- СУИС-ийн “Маркетинг” хөтөлбөр нь сургалтын хөтөлбөрийн агуулгыг маркетинг, реклам зар сурталчилгаа, олон нийттэй харилцах, соёлын худалдаа гэсэн чиглэлээ мэргэшүүлж байгааг агуулгын судалгаа хийж, хөтөлбөрийн сайжруулалт хөгжүүлэлтийг хийх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх цогц чадамжийн зураглалын хүрээнд сургалтыг зохион байгуулдаг.
- CDIO-н сургалтуудад 4 удаа багш нар хамрагдаж, сертификат авсан
- Багш болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн судалгааг хийж, түүний үр дүнгээр сургалтын арга зүйг сайжруулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ онолын мэдлэгийг системтэйгээр бүтээлчээр эзэмших, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, цогц чадамж олгох байдлаар оюутан төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, үйлээр дамжуулан сурах, төсөлд суурилсан, идэвхтэй бүтээлч сэтгэлгээ, мэргэжлийн ёс зүй, бие хүний төлөвшил болон мэргэжлийн ур чадвар, дадлыг хөгжүүлэхэд чиглэгдсэн зарчмыг баримталдаг.

Анхаарах асуудал:

- Сургалтын арга зүйг үнэлэх тал дээр шинэчлэгдсэн дүрэм, журмыг боловсруулах
- Багш нарын сургалтын заах арга зүйг сайжруулахад мэргэжлийн онцлогтой холбоотойгоор шинэчлэх, сургалтад хамруулах

Зөвлөмж:

- Сургалтын арга зүйг хэрэгжүүлж буй байдлын гүйцэтгэлийг үнэлэхдээ түүврээр бус мэргэжлийн хөтөлбөрт хамаарах бүхий л хичээлүүдээр хийх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- “СУИС-ийн бакалаврын сургалтын журам”-д тулгуурлан суралцагчийн үнэлгээг хийдэг.
- Хичээлийн төлөвлөгөөнд тусгагдсан даалгавар, бие даалт, семинар, шалгалт зэргийг үнэлэхдээ хийх ажлын ач холбогдол, агуулга, оюутны оролцоо зэргийг харгалзан үнэлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Цогц чадамжийн зураглалын хүрээнд сургалтын арга зүйг зохион байгуулж, гүйцэтгэлийг хянадаг.

Анхаарах асуудал:

- Сургуулийн uniculture мэдээллийн системд хичээлийн төлөвлөгөө, үйл явц, үнэлгээг хэрхэн хийх талаар тодорхой тусгах
- Суралцагчдыг үнэлэхэд СУИС-ийн дотоод журмыг баримтлан үнэлдэг боловч яг ямар үнэлгээний аргаар үнэлж буйг нарийвчлан тодорхойлох

Зөвлөмж:

- Сургалтын арга зүйг хэрэгжүүлж буй байдлын гүйцэтгэлийг үнэлэх дүрэм, журмыг шинэчлэн сайжруулах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- СУИС нь хоорондоо холбоотой хичээл сургалтын 3 байраас бүрддэг. 2015 оноос эхлэн Соёлын сургууль нь СУИС-ийн хичээлийн II, III байранд сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаагаа явуулж байна. Хичээлийн III байранд хөтөлбөрийн мэргэжлийн хичээл, II байранд ерөнхий суурь хичээлүүд зориулалтын лекцийн танхимуудад зохион байгуулагддаг.
- Өөрийн сургуулийн нөөцөд тулгуурлан анги танхим болон бусад өрөөг дээд боловсролын сургалтын байгууллагын шаардлагад нийцүүлэн засварлаж тохижуулсан.
- Сургуулийн зүгээс жил бүр сургалт явуулах орчныг хөгжүүлэх, стандартад нийцүүлэх тал дээр анхаарч урсгал болон их засвар, хичээлийн байрны өргөтгөл, тоног төхөөрөмж, эд хогшил, худалдан авах зардлыг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Галын аюулгүй байдал, камер хяналтын систем, мэдээллийн терминал зэргийг хүрэлцээтэй байршуулсан байна.
- Иж бүрэн тоноглогдсон лекц, арга хэмжээ зохион байгуулах мэргэжлийн “Оюутан” театртай.
- Соёлын сургуулийн 3-р байрны номын санг засварлаж тохижуулан эрүүл ахуй, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Сургуулийн гадаад орчныг сайжруулж, ногоон байгууламжийг бий болгох
- Сургуулийн дотоод орчны тохижилтын орчинд анхаарах, интернэтийг хурдыг нэмэгдүүлэх, 00-н асуудал, Team working хийх өрөө, багш нартай харилцах өрөө гэх мэт асуудлуудыг шинэчлэн сайжруулах

Зөвлөмж:

- Лабораторид ашиглаж буй иж бүрэн компьютерыг шинэчилж, хүртээмжийг сайжруулах
- Сургалтын цахим орчны хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд оюутнуудад интернэтгүй орчинд нэвтрэх боломжоор хангах

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Соёлын сургууль нь удирдлагын мэдээллийн UNICULTURE систем, KOXA номын сангийн систем болон бусад программ хангамж, цахим хэрэглүүрүүдийг сургалтад ашигладаг.
- Сургуулийн цахим хуудсыг 2016, 2019 онд тус тус шинэчилсэн нь мэдээллийг нээлттэй хүртээмжтэй болгосон.
- СУИС-ийн цахим сургалтын системд нийт 371 багшийн 1468 бакалаврын, (давхардсан тоогоор) 117 ахисан түвшин /магистрантур, докторантур/-ий цахим хичээл тус тус байршиж хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Зайн сургалтын хичээл сургалтыг Moodle программ хангамж дээр тулгуурлан зохион байгуулж байсан бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилд “Open СУИС” цахим сургалтын системийг нэвтрүүлж сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

Анхаарах асуудал:

- Цахим тоног төхөөрөмж, лабораторийн шинэчлэл жил бүр тодорхой хэмжээнд хийгддэг боловч орчин үеийн сургалтын цахим хэрэглүүр, программ хангамжийг нэвтрүүлэх, техник тоног төхөөрөмжийн шинэчлэх шаардлагатай.

Зөвлөмж:

- Орчин үеийн шинэлэг программ хангамжуудыг маркетингийн сургалтад нэвтрүүлэх
- E-Learning системийн хэрэглээг нэмэгдүүлэх тал дээр анхаарах
- Мэргэжлийн болон мэргэшүүлэх суурь хичээлүүдэд ашиглаж буй программ хангамжийг албан ёсны лицензтэй болгон өргөжүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- СУИС-ийн захирлын 2020 оны “Ном, сурах бичиг, гарын авлагыг зурган хэлбэрт оруулах тухай” А/307 тоот тушаал, мөн 2021 оны “Ном, сурах бичиг, гарын авлагыг дотоод сүлжээнд байршуулах тухай” А/09 тоот тушаалаар батлагдсан жагсаалтын дагуу сургалтад ашиглагдах 188 нэрийн ном, сурах бичиг, гарын авлагыг Open SUIS сургалтын системд байршуулсан.
- Мөн МНСК-аас DOAJ - THE DIRECTORY OF OPEN ACCESS JOURNALS, DOAB DIRECTORY OF OPEN ACCESS BOOKS гэсэн 2 мэдээллийн санг ашиглах боломжийг нээж өгсөн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийтийн, эрдэм шинжилгээний, цахим, хөгжим сонсголын танхимуудаар гэрээр болон танхимаар ном, сурах бичиг олгох, сонин сэтгүүл уншуулах, цахим ном, сонин уншуулах, сонгодог болон ардын хөгжим сонсгох, дуурь, жүжгийн DVD үзүүлэх, эрдэм шинжилгээний бүтээлүүдийг уншуулах гэх мэт олон төрлийн үйлчилгээг үзүүлдэг.

Анхаарах асуудал:

- Номын сангийн цахим сан хөмрөгийн баяжилт E-сэтгүүл, E-диссертац фонд бүрдүүлэлтийг сайжруулах
- Мэргэжлийн ном, сурах бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, сүүлийн жилүүдэд туурвигдсан гадаад болон дотоодын бүтээлүүдээр ном, сурах бичгийн захиалгыг нэмэгдүүлж, баяжуулалт хийх

Зөвлөмж:

- Гадаад номын захиалгын тоо болон нэгж номын тоо ширхгийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах
- Хөтөлбөрөөр суралцагчдын цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэр ашиглах боломжийг нэмэгдүүлж, суралцагчдад түүнийг хэрхэн ашиглах чиглэлийн зөвлөмжүүдийг тогтмол өгдөг байх
- E-Номын сангийн үйлчилгээг сайжруулах

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Соёлийн сургуулийн “Соёлын үйлдвэрлэлийн тэнхим” нь сүүлийн 5 жилд СУИС-ийн хэмжээнд “Шилдэг тэнхим” өргөмжлөл хоёр удаа авсан, арвин их туршлагатай, амжилт бүтээл өндөр хамт олон гэдгээ нотлон харуулсан байна.
- Соёлын үйлдвэрлэлийн тэнхим нь 1990 оноос эхлэн Маркетинг хөтөлбөрийг хөгжүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэхтэй холбоотой шийдвэрүүдийг

холбогдох дүрэм журмын дагуу өргөжүүлэн хөгжүүлж, тасралтгүй шинэчлэлт хийж хэрэгжүүлсэн байна.

- Хөтөлбөрийн хороо, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл, хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн байдалтай танилцахад хөдөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүд бүрдсэн байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь урт болон богино хугацааны төлөвлөгөөтэй, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн тайлан, ахиц дэвшил, өөрчлөлтийг хийдэг механиз бүрдсэн гэж үзэж болно.
- СУИС-ийг хөгжүүлэх үзэл баримтлал, зорилго стратегийн үндсэн зорилтууд 2018-2024 оны Мастер төлөвлөгөөнд үндэслэн жил бүрийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж байна.
- СУИС нь сургалтын удирдлагын мэдээлэл, хяналтын системийг боловсронгуй болгох ажлын хүрээнд ШУТИС-тай хамтран UNIMIS системийг 2010 оноос нэвтрүүлж эхэлсэн. 2012 оноос UNICULTURE системийг нэвтрүүлж, энэ систем нь сургууль тэнхимийн мэдээллийн нэгдсэн бааз ба дотоод хяналт шинжилгээ, чанар, гүйцэтгэлийн үнэлгээний чухал хэсэг болж байна. 2016 оноос мэдээллийн системийг сайжруулснаар оюутны болон багшийн сэтгэл ханамжийн авч байх өргөтгөл хийгдсэн төдийгүй мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нэгдсэн тайлан, төлөвлөлт хийх боломж бүхий удирдлагын мэдээллийн дэд систем бий болжээ.
- 2020 оноос “OPEN MNUAC” цахим сургалтын системийг сургалтад нэвтрүүлсэн. Энэ нь СУИС-ийн дотоод удирдлагын системтэй бүрэн холбогдсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, хяналт- шинжилгээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд (KPI- Key Performance Indicator) –г тодорхойлон, 2024 онд хүрэх түвшинг төлөвлөн ажиллаж байна.
- Бүс нутгийн шилдэг сургуулиудын эгнээнд багтсан “Соёл Урлагийн төрөлжсөн Их Сургууль болох” алсын хараа, Үндэсний Соёл Урлагийн гол уурхай болох эрхэм зорилгодоо хүрэхийн тулд стратегийн 4 тэргүүлэх чиглэл, үндсэн 16 зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.
- СУИС-ийн Соёлын сургуулийн Соёлын үйлдвэрлэлийн тэнхим нь Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд “Маркетинг” хөтөлбөрт 2016, 2018, 2020 онд тасралтгүй шинэчлэлт хийж, Монгол улсад Соёлын бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэхэд “Сургалт- Судалгаа, эрдэм шинжилгээ-инноваци”-ийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Зөвлөмж:

- Олон Улсын стандартад нийцсэн боловсролын үйлчилгээг үзүүлж, соёлд суурилсан нийгмийг цогцлоох манлайлагчдыг бэлтгэдэг соёлын судалгааны их сургууль болох менежментийн тогтолцоог бүрдүүлэх
- Төрийн болон төрийн бус байгууллагууд, гадаад дотоодын мэргэжлийн холбоод, уран бүтээлчид, хувийн сектортой хамтран ажиллах бодлого боловсруулж хэрэгжүүлэх
- Санхүү, эдийн засгийн төлөвлөлт, төсөвлөлтийн уялдааг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэхийн тулд “хөрөнгө, эх үүсвэрийн удирдлагын оновчтой тогтолцоо”-г төлөвшүүлэх
- Санхүүгийн олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хамтран ажиллах соёлын байгууллагуудын нөөцийг ашиглах замаар хөрөнгө оруулах болон урсгал зардлуудыг бууруулах боломж бүрэн байна.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон Улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Өнөөгийн байдлаар Соёлийн үйлдвэрлэлийн тэнхим нь Соёл урлагийн төрийн бодлогод хувь нэмэр оруулахуйц өргөн цар хүрээтэй судалгаануудыг системтэй явуулж байна.
- 2012 оноос хойш 70 орчим төсөл, гэрээт ажлууд гүйцэтгэж томоохон тайлан бичсэн үр дүнгүүдтэй танилцсан. Үүний дотор Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр хийсэн судалгаа шинжилгээ, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллэгүүд, эрдмийн бүтээл зонхилж байна.
- Жил бүр Үндэсний их баяр наадмын өдрүүдэд “Соёлын наадам” фестиваль, урлаг соёлын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллуулдаг уламжлалтай. Энэ үйл ажиллагаанд багш, оюутан идэвх зүтгэлтэй оролцдог.
- Мөн уламжлал болгон зохион байгуулагддаг “Соёл урлагийн ажилтны Улсын зөвөлгөөн”, “Монголын инновацын 7 хоног”-ийн хүрээнд “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж хэвшүүлсэн. Энэ жил энэхүү ЭШБХ улам өргөжин тэлж 3 салбар хуралдаан болсон байна.
- Үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг “Маркетингийн менежментийн олимпиад”-д жил бүр амжилттай оролцож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн 4 жилд хийсэн нэг томоохон төслийн жишээ бол *“Соёл урлагийн үндэсний ажил мэргэжлийн индекс, ангилал ба тодорхойлолт өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах”* төслийн тайлан бичиж БСШУЯ-нд хүлээлгэн өгчээ. Тайлангийн хавсралтуудаар Урлагын байгууллага, Соёлын аялал жуулчлал, Соёлын ордон /төв/, Дүрслэх урлаг, Музей, Номын сан, Соёлын байгууллагын ажилтнуудын ажил үүргийн тодорхойлтуудын 6 боть ном хэвлүүлсэн байна.
- Монгол орны 21 аймаг 330 сумын соёлын төвүүд, клуб, улаан буланг хамруулан *“Соёл Урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв (2018-2023)”* төслийн тайланг бичсэн бүтээл нь маш үнэ цэнэ бүхий ажил болжээ.

Анхаарах асуудал:

- Уламжлалт соёл, сонгодог урлагийг судлах, сурталчлах, маркетингийн идэвхжүүлэлт хийх, бүх нийтийн соёл, урлагийн боловсролыг дээшлүүлэхүйц хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх. Бүх нийтийг соён гэгээрүүлэх өргөн далайцтай ажлуудыг соёлын маркетингийн мэргэжлийн оюутнуудын тусламж дэмжлэгтэйгээр хийж хэвшүүлэх. Оюутны бие даалтын ажлуудыг энэ чиглэлд төвлөрүүлэх
- Урлаг, уран сайхны үндэсний хэмжээний хөтөлбөр, төсөлт ажлуудыг санаачлан хэрэгжүүлэх, нийгэмд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх
- Сургуулийн удирдлагын бүх шатанд манлайлалыг хөгжүүлэх, тэднийг үнэлэх, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх

Зөвлөмж:

- Гадаадын их, дээд сургуулиудтай үр өгөөжтэй хамтран ажиллах, зорилтот элсэгчдэд чиглэсэн олон талт тэтгэлгийн эх үүсвэрүүдийг бий болгох;
- Багш, оюутны гадаад хэлний мэдлэгт бодлогоор дэмжлэг үзүүлэх, солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах доривтой ажил зохион байгуулах;
- Оросын Холбооны Улсын Буриад, БНХАУ-н Өвөр Монгол үндэстнүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, тэдэнтэй туршлага солилцох;
- Улаан-Үдэ, Эрээн хот, Хөх хотын соёл урлагийн сургуультай хамтран багш, оюутан солилцоо хийх, оюутан элсүүлж авах, тэдгээр хотуудын урлагын хамтлага, соёлын төвүүдтэй гэрээт ажил хийж, хэрэгжүүлэх;
- Төгсөгчдийг тогтмол давтан сургалтад хамруулж, төгсөгч оюутны үйл ажиллагааг өргөжүүлэх;

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Соёлын сургуулийн багш нар СУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад дээд боловсролын суурь хичээлүүдийг заадаг бөгөөд энэ нь сургууль хоорондын тооцоогоор хийгддэг. СҮТ-ийн багш нар бүрэлдэхүүн сургуулиудад хүний хөгжил, эдийн засаг хичээлүүдийг зааж байна.
- Сүүлийн 5 жилийн санхүүгийн тайлангаар тус мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудад зориулсан арга хэмжээний нийт төсөв жил бүр нэмэгдсэн байна. Ялангуяа хоёр жил тутамд зохион байгуулагддаг уламжлалт Маркетингийн менежментийн Улсын олимпиадад болон сургуулийн хэмжээний соёл урлагийн маркетингийн олимпиад, Creative week, “Бүтээлч үйлдвэрлэл” хөгжлийн семинар зэрэгт төсөв илүү хэмжээгээр төсөвлөгдөж байна.
- Сүүлийн жилүүдэд “Бүтээлч оюутан” төслүүдийг жил бүр хэрэгжүүлснээр хичээл сургалт, оюутны үйлчилгээний зардал өмнөх онуудаас нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Маркетинг мэргэжлийн ангийн оюутнуудын бүтээл болох төсөл хөтөлбөрүүд нь жил бүр сайжирч “Бүтээлч төсөл” хөтөлбөрөөр шалгарч жилд дунджаар 3.0-5.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий санхүүжилтийг оюутны хөгжилд оруулсан байна.
- Багш оюутны бүтээлч санаачлагын хүрээнд тухайн хөтөлбөрийн чиглэлээр гадаад дотоодын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлснээр оюутны нийгмийн идэвхи санаачлага нэмэгдсэн төдийгүй жил бүр төслийн санхүүжилт, тоо хэмжээг нэмэгдүүлж байна. Жилд дунджаар багш, оюутныг хамруулсан төсөл 34.2 %-аар нэмэгдсэн байна.

Анхаарах асуудал:

- Өндөр ур чадвартай, ажлын дадлага туршлагатай, бүтээлч сэтгэлгээтэй мэргэжилтэн, мэргэшсэн судлаачдыг сургалтад татан оролцуулах таатай нөхцөл бүрдүүлэх
- Багшийн заах ур чадвар, судалгааны онол, арга зүйг дээшлүүлэхэд анхаарч, профессор багшийн ажлын үнэлгээ, урамшууллын системийг боловсронгуй болгох

Зөвлөмж:

- Маркетинг хөтөлбөр орлогын өөр эх үүсвэртэй болох боломж бололцоотой тул удирдлагын зүгээс анхаарч, багш, оюутны санал санаачилгыг дэмжих;
- Оюутныг суралцах хугацаандаа ажлын дадлага туршлага хуримтлуулах, хөдөлмөрийн зах зээлд гарахад нь туслах үйлчилгээний төрөл хэлбэрийг олшруулах, бодит дэмжлэг үзүүлэх;

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Технологийн хөгжил, нийгэм соёлын өөрчлөлт, хэвлэл мэдээлэл, зах зээлийн эрэлт хэрэгцээ, хэрэглээ өөрчлөгдөж, шинэ зах зээлд ажиллах маркетингийн мэдлэгээ нэмэгдүүлэх, соёлын маркетингийн шинэ бодлого хэрэгжүүлэх шаардлага гарч ирж байна.
- Хөтөлбөрийг олон нийтэд таниулах, элсэгчдэд зориулсан олон арга хэмжээнүүд зохион байгуулж байгаа ч гэсэн элсэлт бага, суралцагч оюутны тоо цөөхөн байна.
- Хөтөлбөрийн хүрээнд тогтмолжуулсан хэд хэдэн ажлууд хийгдэж байна. Үүнд: MYOHT Монголын нэг өдөр, CREATIVE WEEK, Мэргэжил сурталчлах өдөрлөг “Амгалан орчлон- Амгалан Улаанбаатар”, “Миний нутаг- Хотын гудамж”, “Бид сайн сайханд дагуулна” гудамжны урлагын баяр, “Манай төгсөгчид Бидний бахархал” цуврал видео кино.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Мэдээллийн хангалттай олон суваг ашиглаж байгаа нь давуу талтай.

Анхаарах асуудал:

- Мэдээллийн сувгуудаар дамжуулан хүргэж буй контентуудыг илүү сонирхолтой хэлбэрээр, тодорхой давтамжтайгаар тогтмол хүргэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд анхаарах
- График дизайнер, энтертаймент, мультимедиа, контент хөгжүүлэлтийн мэргэжилтнүүдийг бодлогоор бэлтгэх

Зөвлөмж:

- Соёл Урлагийн Маркетингийн мэргэжлийн хөтөлбөрийг сурталчлан таниулах facebook хаяг нээх;
- Соёлын үйлдвэрлэлийн тэнхим нь өөрөө Мэдээлэл, технологийн сүүлийн үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хагагдсан байх нөхцөлийг бүрдүүлэх
- Хичээлийн хөтөлбөртөө график дизайны хичээл оруулах;

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг дамжуулах сувгууд
- Сургуулийн вэбсайт, оюутны гарын авлага, сургуулийн, оюутны, төгсөгчид, холбоодын facebook,

- Сургуулийн мэдээллийн баазыг хариуцсан алба, мэргэжилтэнг томилон, өдөр тутмын болон холбогдох үйл ажиллагааны мэдээллийг нээлттэй хүргэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Маркетинг хөтөлбөрийг шинэчлэн сайжруулахдаа нээлттэй ид тод байх зарчимд үндэслэн "Соёл урлагийн маркетинг" олимпиад, "Creativ week" арга хэмжээний үеэр ажил олгогч, төгсөгчид, профессор багш нар, оюутнуудын хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулан ажилласан. Энэхүү хэлэлцүүлгээр хөтөлбөрийн өнөөгийн байдал, соёл урлагийн салбарт маркетинг мэргэжлээр ажиллахад ямар ур чадвар шаардлагатай байгаа, юунд анхаарах талаар ярилцаж, санал бодлоо ил чөлөөтэй ярилцаж, үр дүнд нь "Маркетинг" хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг шинэчилсэн байна.
- Олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа тогтмолжсон, мэдээллийн олон эх үүсвэрийг ашигладаг зэрэг нь давуу талтай.

Зөвлөмж:

- Соёлын өв (биет ба биет бус)-ийг системтэй судалж, үндэсний соёл урлагийг дэлхий дахинаа таниулахад бодитой хувь нэмэр оруулах чиглэлээр төгсөх ангийн оюутнууд дипломын сэдэв өгч ажиллуулах;
- Төгсөх оюутнуудын төгсөлтийн ажлын сэдвийг соёлын үйлдвэрлэлийн тэнхимээс бодлогоор санал дэвшүүлж, сонгуулах;
- Төгсөлтийн ажил, судалгааны бүтээлийн нэгдсэн "сан" байгуулж нийтийн хүртээл болгож ажиллах;

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- СУИС-ийн Соёлын Сургуулийн Маркетинг хөтөлбөрөөр элсэгчдийг сонгон элсүүлэхдээ Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайдын 2018 оны А/194 тоот "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тушаалын хавсралт, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/47 тоот тушаалаар батлагдсан "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тушаал, Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайдын "Босго оноо тогтоох тухай" А/195 тоот тушаал, Соёл урлагийн Их сургуулийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/90 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт "Бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх журам" зэрэгт үндэслэн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- Бакалаврын хөтөлбөрт элсэхийг хүсэгч нь бүрэн дунд, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх ба элсэлтийн ерөнхий шалгалт ЭЕШ-ын босго оноо, элсэлтийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хугацаа, хураамжийг тухайн

жилийн элсэлтийн журамд тусгаж, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан хяналтын тоог баримталдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургууль нь өөрийн элсэлтийн журамтай.
- Шинэ элсэгчдэд зориулсан гарын авлагатай, хичээлийн жил бүр тогтмол шинэчлэн гаргадаг.
- Хөтөлбөрөөр бүртгүүлсэн болон элсэгчдийн харьцаа тэнцвэртэй.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилгын онцлогтой уялдуулан элсэгчдэд тавигдах шаардлагаа шинэчлэн сайжруулах

Зөвлөмж:

- Элсэгчдийн тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарах;

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- СУИС-ийн стратегийн төлөвлөгөө, бүтцийн сургуулиудын хичээлийн жилийн нэгдсэн төлөвлөгөө болон нэгжүүд, зөвлөх багш нарын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу зөвлөн туслах үйлчилгээг хэрэгжүүлдэг.
- СУИС-ийн хэмжээнд 2018 оны 4 сарын 24-ны өдрийн 146-р тоот тушаалын хавсралтаар батлагдсан “СУИС-ийн оюутны зөвлөх багш ажиллуулах журам”-ыг сургалтын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Оюутны хөгжлийн төв” ажиллуулж элсэгч, оюутан, эцэг эх болон хамтрагч байгууллагуудад 1 цонхоор мэдээлэл өгдөг. Уг төвдөө 2-3 курсийн оюутнуудыг нэмэлтээр ажиллуулдаг.
- СУИС нь 2018 онд СУИС-ийн “Оюутны хөгжил хөтөлбөр (2018-2022)-ийг боловсруулан, баталж, зөвлөн туслах үйл үйлчилгээний хүрээнд оюутныг чиглүүлэх, зөвлөх үйлчилгээ, оюутны хөдөлмөр эрхлэлт, оюутны дотуур байр, Харзтайн “Эгшиглэн” эко зуслан, оюутны санаачилгатай төсөл хөтөлбөр, тэтгэлэг хөтөлбөрт хамруулж санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, сайн дурын ажил, нийгмийн үйлчилгээ, соёл, эрүүл мэнд, спорт наадам, оюутны байгууллага, зөвлөл, клубүүд ажиллуулах үйлчилгээ зэрэг ажлыг үе шаттайгаар төлөвлөн, хэрэгжүүлж байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн байр хоорондоо зайтай тул оюутнуудын аюулгүй байдлыг хангах талд бодлогын түвшинд дэмжлэг үзүүлэх

Зөвлөмж:

- Суралцагчдын эрдэм шинжилгээний ажлыг хөхиүлэн дэмжих болон сайн дурын үйл ажиллагааг нэмэгдүүлэх;

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- СУИС нь “Оюутан хөгжлийн төв, оюутны зөвлөл (ОЗ), СУИС-ийн оюутны холбоотой ба оюутны зөвлөлөөр дамжуулан оюутнуудынхаа эрх ашгийг хамгаалах, оюутан залуусын шинэ санааг дэмжиж, аливаа зохион явуулж буй үйл ажиллагаанд оюутан залуусыг идэвх санаачилгатай оролцуулах, оюутнуудынхаа нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг.
- СУИС-ийн оюутны холбоо нь бүтцийн 6 сургуулийн оюутны зөвлөл, клубүүдийн зөвлөл, гадаад оюутны зөвлөл, оюутны дотуур байрны зөвлөл нийт 9 зөвлөлөөс бүрддэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн оюутанд тэтгэлэг урамшуулах олгох ажлыг Засгийн газрын 2008 оны 177 тоот тогтоол, Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад “Төрийн буцалтгүй тусламж олгох журам”, ЗГ-ын 2014 оны 71 тоот тогтоол “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад сургалтын тэтгэлэг олгох журам”, СУИС-ийн захирлын 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/234 дугаар тушаал “СУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох журам”, СУИС-ийн захирлын 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/149 дугаар тушаал “СУИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг” олгох журмуудад үндэслэн хэрэгжүүлдэг.

Анхаарах асуудал:

- “СУИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг” олгох журамд хөтөлбөрөөр суралцагчдад олгох урамшууллын тогтолцоо байгаа хэдий ч нэг оюутан суралцах хугацаандаа ганцхан удаа тэтгэлэг авах боломжтой байгааг хүртээмжтэй болгоход анхаарах

Зөвлөмж:

- Мэргэжлийн олимпиад, уралдаан тэмцээнд суралцагчдыг идэвхжүүлэн дэмжиж, үр дүн гаргасан суралцагчдад урамшуулал олгоход анхаарах

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- СУИС-ийн Соёлын сургуульд гадаад, дотоодын дээд сургуулиудаас оюутан шилжин суралцах, мөн СУИС-ийн бүрэлдэхүүн сургууль хооронд шилжүүлэн суралцуулах, сургуулиас чөлөөлөх зэрэг үйл ажиллагааг “СУИС-ийн бакалаврын сургалтын журам”-ын 5-д заасны дагуу зохицуулж байна.
- Сүүлийн 5 жилийн байдлаар Маркетинг хөтөлбөрийн 4 оюутан жилийн чөлөө авч, 10 оюутан жилийн чөлөөнөөс орж ирж, нийт 5 оюутан сургуулиас гарсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ оюутан тус бүрээр зөвлөх багш нь сургалтын алба, СУИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газартай хамтран кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх ажлыг хийж, шилжин суралцаж буй оюутан “Дүйцүүлэлтийн хуудас”-д шийдвэрлэсний дагуу үргэлжлүүлэн суралцдаг.

Анхаарах асуудал:

- Суралцагчдыг сургуулиас гарах, жилийн чөлөө авах, эсвэл шилжин суралцах байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор санал, өргөдлийн системдээ тулгуурлан ирээдүйн шилжих хөдөлгөөний асуудлыг төлөвлөдөг байх

Зөвлөмж:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгааны үр дүнд бодлогын хувьд үйл ажиллагаагаар дэмжин гүйцэтгэж, ахиц дэвшлийг үнэлдэг байх;

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичгийн загвар
- Төгсөлтийн баримт бичгийг олгох журмын хэрэгжилтийн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичгийн загвар болон төгсөлтийн баримт бичгийг олгох журмын хэрэгжилт нь Дээд боловсролын тухай хууль, БСШУЯ-аас баталсан нийтлэг загвар стандартад бүрэн нийцсэн байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Соёлын сургууль нь хүний нөөцийн бодлого, зохицуулалтын хүрээнд СУИС-ийн 2020 онд шинэчлэн боловсруулсан дүрэм журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж байна.

- Маркетинг хөтөлбөрийн сургалтад докторын зэрэгтэй 4 багш, докторантурт суралцдаг 4 багш, докторантурын сургалт дүүргэж сертификат авсан 2 багш ажиллаж байна.
- Сүүлийн 5 жилд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 2 багш доктор (Ph.D)-н зэрэг хамгаалсан. Түүний нэг нь тус тэнхимийн эрхлэгч, хөтөлбөрийг үүсгэн байгуулагчдын нэг Ж.Эрхэмтөгс бөгөөд одоо СУИС-ийн Эрдэм шинжилгээ-Инновац эрхэлсэн захиралаар ажиллаж байна.
- СУИС-ийн багш нарыг аттестатчилах журмыг үндэслэн, мөрдлөг болгон, багшийн зэрэглэлд тавигдах шаардлагад нийцсэн байдалд үнэлгээ өгч ажиллаж байна.
- Нэг профессор багшид ногдох бакалаврын оюутны дундаж тоо 15 байна.
- Маркетинг хөтөлбөрийн тэнхим нь СУИС-ийн “Шилдэг тэнхим” өргөмжлөлийг 2 удаа авсан нь тухайн тэнхимийн багш нарын нөр их хөдөлмөрийн үр дүн гэж үзэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүн ерөнхийдөө залуучуудаас бүрдсэн нь давуу талтай.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын ажлын үр дүнг жил бүр удирдлага, хамт олны үнэлгээгээр дүгнэж урамшуулдаг. Үнэлгээг дараах 10 үзүүлэлтээр 10 хүртэл оноогоор үнэлдэг. Үүнд: Их сургуулийн багшийн түвшний мэргэжлийн үр чадвартай эсэх, багшлах заах арга зүйг эзэмшсэн эсэх, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй эсэх, сургалтаас гадуурх ажилд идэвхтэй оролцдог эсэх, багшийн ёс зүйтэй эсэх, цаг баримталдаг эсэх, багаар ажиллах, удирдан зохион байгуулах чадвар, шудрага, зарчимч, хариуцлага хүлээх чадвартай, харилцааны соёл, ажлын байрны хувцаслалтанд анхаарч, биеэ зөв боловсон авч явдаг эсэх үзүүлэлтүүдээр үнэлгээ өгдөг.

Анхаарах асуудал:

- Тэнхимийн багш нарын Б, В цаг их гүйцэтгэлтэй байдаг. А цаг руу шилжүүлэх боломж байхгүй байдаг нь багшийн биеийн хөдөлмөрт их нөлөөлдөг. Энэ асуудлыг суралцагч оюутнуудын уулзалт дээр хэд хэдэн оюутан хөндөж ярьсан.
- Сургуулийн бодлогоор докторын сертификат авсан багш нарт богино хугацаанд бүтээлийн чөлөө олгож, докторын зэрэг хамгаалуулах
- Маркетинг хөтөлбөрийн мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийн үндсэн сурах бичиг гаргах ажлыг төлөвлөгөөтэй зохион байгуулах

Зөвлөмж:

- Гадаадын сургуулиудтай хамтарсан докторын хөтөлбөрт багш нарыг хамруулж, зэрэг хамгаалахад дэмжлэг үзүүлэх;
- Оюутнуудын хамгийн их сэтгэл ханамжтай оролцдог хичээл бол Дадлагын хичээл, цогц бие даалтын хичээл гэж үнэлгээ өгч байгаа нь маш чухал үнэлгээ юм. Соёлын маркетинг хөтөлбөрийн онцлог ч байж болно. Иймээс энэ хичээлийн цаг, үнэлэмжийг нэмэгдүүлэх боломжийг судлах;

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн жилийн эхэнд багш бүр багшийн хөгжлийн төлөвлөгөө гаргаж батлуулдаг. Тухайн хичээлийн жилийн эцэст төлөвлөгөөний гүйцэтгэлд Соёлын сургуулийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга хяналт тавьж ажилладаг.
- Маркетинг хөтөлбөрт мэргэжлийн хичээл заадаг багш нарын эрдмийн зэрэг цолны хувь хэмжээ жилээс жилд нэмэгдэж байна. Өнөөдөр магистрын зэрэгтэй 5, докторын зэрэгтэй 4 багш ажиллаж байна.
- Маркетинг хөтөлбөрийн мэргэжлийн нэг багшид ногдох оюутны тоо 1/5 байна. (багш 9, оюутан 46)
- Хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүний ажлын туршлага өндөр гэж үзэж болно. Үүнд: 1-10 жил ажилласан 1, 10-20 жил ажилласан 4, 21-ээс дээш жил ажилласан 4 багш байна. Насны хувьд 30 хүртэл насны 1 багш, 30-50 хүртэл насны 6 багш, 51- ээс дээш 1 багш, 61-ээс дээш 1 багш ажиллаж байгаа нь харьцангуй залуу бүрэлдэхүүн гэж үзэж байна.
- Маркетинг хөтөлбөрийн мэргэжлийн багш нарын албан тушаалын зэрэглэлийг авч үзвэл: багш-4, ахлах багш- 3, дэд профессор-1, профессор-1 зэрэглэлтэй багш нар хичээл сургалт явуулж байна
- СУИС-ийн болон Соёлын сургуулийн шилдэг багшаар сүүлийн 3 жилд маркетинг хөтөлбөрийн багш нараас 5 багш шалгарч байсан байна. Үүнд: “Шилдэг судлаач” багшаар Ж.Эрхэмтөгс, “Шилдэг залуу багш”-р М.Гэрэлмаа, “Шилдэг сурган хүмүүжүүлэгч” багшаар Ш. Оюундэлгэрэх, Соёлын сургуулийн “Шилдэг багш”-р П. Баасангэрэл, Н. Туул нар тус тус шалгарсан байна.
- Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд ч онцгойлон тэмдэглэсэн нэг асуудал бол багш солилцоо, оюутан солилцоо, гадаадын их дээд сургуулиудтай хамтран ажиллах, зочин профессор урьж ажиллуулах, өөрсдөө зочилж ажиллах боломж нөхцөл хангалтгүй байна. Хамгийн чухал нь хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын гадаад хэлний түвшин хангалтгүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын эрдэм судлалын ажлын цар хүрээ өргөжин тэлж, соёлын бодлого, соёлын бүтээлч үйлдвэрлэл, оюуны өмчийн эрхийн асуудал зэрэг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эрдмийн бүтээлүүд хийгдэж байна
- 2017 онд Ж. Эрхэмтөгс “Монголд соёлын бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх арга зам” сэдвээр, 2020 онд М.Гэрэлмаа “Монгол улсад зохиогчийн эрхэд суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь” сэдвээр, 2021 онд Ш. Оюундэлгэрэх “Соёлын байгууллагын үйлчилгээний чанараар бодлогын хэрэгжилтийг үнэлэх нь” сэдвээр тус тус доктор (Ph.D) зэрэг хамгаалсан нь Соёлын маркетинг хөтөлбөр хэрэгжүүлэхэд маш чухал суурь судалгаанууд болсон гэж үзэж байна.

Шаардлага:

- Багш нарын гадаад хэлний мэдлэг, боловсролыг үр өгөөжтэй дээшлүүлэх, бодлогоор Маркетинг хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийг англи хэл дээр заадаг болох хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Гадаад дотоодын их дээд сургуулиудтай багш солилцоог идэвхтэй хийх арга замыг эрэлхийлэх;

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Маркетинг хөтөлбөрийн багш нар эрдэм шинжилгээ , судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны ажлын үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үнэлэхүй үр нөлөөтэй байна.
- Сүүлийн 5 жилд тэнхимийн багш нар 49 эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл бичиж хэвлүүлсэн байна.
- Гадаадад хэвлүүлсэн өгүүллэгийн тоог нэмэгдүүлэх, цаашид судалгааны эрчимжүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн импакт-фактор өндөртэй сэтгүүлд хэвлүүлэхэд нь дэмжлэг болж сургуулиас мөнгөн тусламж олгохоор шийдвэрлэсэн байна.
- Маркетинг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар нь сургалт судалгааг практиктай хослуулах, соёл урлагийн салбарын хүний нөөцийг чадвахжуулах, давтан сургах, шинэ мэдээллээр хангах зорилгын үүднээс “Соёл урлагийн боловсролын тогтвортой хөгжил I,II” төсөлд идэвхтэй оролцож орон нутагт сургалт зохион байгуулж, хичээл сургалт явуулж, богино хугацааны сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн.
- Түүнчлэн “Дижитал маркетинг- 1” хичээлийн хөтөлбөр боловсруулан 2 кредитийн сургалтыг орон нутгийн Соёлын төв болон соёлын ордны 430 гаруй соёл, гэгээрлийн удирдах ажилтнуудад амжилттай явуулсан байна.
- Соёлын сургууль нь “Монгол соёл иргэншлийн үүсэл, түүхэн хөгжлийн мөн чанар, аюулгүй оршихуйн язгуур дархлаа ба даяаршлын үр дагаварын судалгаа” –ны тэргүүлэх чиглэлүүдийг тогтоож Үндсэн 3 чиглэл, 7 дэд чиглэлээр эрдэмтэн судлаачид, суралцагчдыг удирдан чиглүүлж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Маркетинг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн багш нарын эрдэм судлалын судалгааны үндсэн чиглэлүүд нь хөтөлбөрийг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд маш дөхөмтэй сэдвүүд байна.
- Соёлын үйлдвэрлэлийн тэнхимийн багш нар нь СУИС-ийн дэргэдэх “Бүтээлч үйлдвэрлэл-инновацын төв”-тэй хамтран олон Улсын болон үндэсний хэмжээний захиалгат төсөл, судалгааны ажлуудад амжилттай ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүнээс шинээр патент авсан, зохиогчийн эрх авсан бүтээлүүд хараахан гараагүй байна. Энэ нь багш нарын эрдэм шинжилгээний бүтээл туурвих, ном сурах бичиг бичиж хэвлүүлэх, инноваци нэвтрүүлэхүйц бүтээл туурвих нөхцөл боломж дутмаг, урамшуулал, дэмжлэг шаардлагатай байгааг харуулж байна.

Зөвлөмж:

- Гадаадын нэр хүндтэй /peer review хийгддэг/ сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлсэн багш нарын тоо бага байгаад анхаарч, дэмжиж ажиллах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- СУИС,Соёлын сургуулийн багшийн үнэлгээний аргачилал боловсруулан Сэтгэл ханамжийн судалгааг оюутнаас улирал тутамд, төгсөгчдөөс жил бүр, ажил

олгогчдоос жил бүр авч үр дүнг боловсруулан хөтөлбөрт хийх сайжруулалт, өөрчлөлт зэргийг тодорхойлдог.

- Багшийн ажлын гүйцэтгэлийг холбогдох журмын дагуу удирдлагын мэдээллийн системд үнэлж дүгнэдэг.
- Багшийн өөрийн үнэлгээний тайланг дүгнэх тогтсон үзүүлэлтүүдийг мөрддөг.
- Хөндлөнгийн үнэлгээг удирдлага, оюутнуудаас авч дүгнэдэг.
- Санал асуулгын үр дүнгээр хөтөлбөрийн багш нарын ур чадварыг оюутны сэтгэл ханамжийн судалгаанаас үзэхэд “Маркетинг” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн багш нарын үнэлгээ хангалттай сайн гэсэн үзүүлэлт гарсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

Судалгааны үр дүнгээс харахад дараах асуудлуудад анхаарах шаардлагатай.

- Багшийн өгч байгаа даалгаварууд нь тухайн хичээлийг гүнзгийрүүлж ойлгоход тусалдаг, уншиж судлах эх сурвалжуудыг тодорхой зааж өгдөг байх, багш оюутантай хамтран ажиллах, чиглүүлэх үйл ажиллагаанд дэвшил гаргах
- Хоцрогдсон хичээлийг нөхөх болон давтан судлах боломжийг өргөтгөх, багшийн зөвөлгөө өгөх цагийг ил тод нээлттэй болгох
- Багшийн заадаг хичээлийн файл бүрдүүлэлтийг боловсронгуй болгох шаардлагатай. Мэргэжлийн шинэ ном сурах бичгийн баяжуулалт хийх, судлаж жагсаалт гаргах.
- Үр дүнд суурилсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг СУИС-ийн мастер төлөвлөгөөний ахиц дэвшлийн шалгуур үзүүлэлтүүдтэй холбож уялдуулах

Зөвлөмж:

- Соёлын сургууль, соёлын үйлдвэрлэлийн тэнхимийн академик нэр хүндийг дээшлүүлэх цогц төлөвлөгөө гаргаж ажиллах;
- Гадаадын зочин профессор багш ажиллуулах, гадаадын оюутан элсүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Гадаадын зочин профессор, гадаадын оюутан хүлээн авах бэлтгэл ажлын хүрээнд тэнхимийн багш нар багшийн хөгжлийн төлөвлөгөөндөө тодорхой ажлууд тусгаж мөрдөх;

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагаа, гүйцэтгэл, үр дүнг бодитойгоор үнэлэх, хүрсэн түвшнийг баталгаажуулах, амжилт, доголдол, бэрхшээлийг тодорхойлох, удирдлагыг цаг үеэ олсон үнэн зөв мэдээллээр хангахад зориулагдсан “СУИС-ийн үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээний журам”-ыг захирлын 2012 оны 2-р сарын 29-ны өдрийн А/75 тушаалын IV хавсралтаар баталсан байна.
- Захирлын 2016 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/93 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар тус сургуулийн Сургалтын бодлого зохицуулалтын газрын

“Сургалтын хөтөлбөр, чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн”-ий ажлын байр, (албан тушаал)-ны тодорхойлолтыг хавсралтаар баталсан.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дотоод чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөрийг 3 үе шаттай хэрэгжүүлж байна.
- “СУИС-ийн үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээний журам” -ыг захирлын 2012 оны 2-р сарын 29-ны өдрийн А/75 тушаалын IV хавсралтаар баталсан.

Анхаарах асуудал:

- Сургуулийн удирдлагын бүтэц зохион байгуулалтад чанарын дотоод баталгаажуулалтын нэгжийг төв сургуульд төвлөрүүлсэн нь учир дутагдалтай бөгөөд удирдлага, зохион байгуулалтын бүтцэд чанарын удирдлагын нэгжийг салбар сургууль руу төвлөрүүлэх;
- Дотоод чанарын баталгаажуулалтын удирдлагыг хэрхэн явуулах журмын агуулгыг сайжруулж, шинэчлэн сайжруулах;

Шаардлага:

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж сайжруулахдаа оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад хэр нийцэж байгааг судалж үнэлэлт, дүгнэлт өгөх
- Оролцогч талуудын судалгааг сургуулийн хэмжээнд нэгтгэн гаргаж, тогтмолжуулах;

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн мөшгих судалгааг хийж, судалгааны үр дүнг нь хөтөлбөрийн шинэчлэлтэд ашигладаг.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах үйл ажиллагааг схемчилсэн байдлаар тодорхойлсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах үйл ажиллагааг схемчилсэн байдлаар тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- Оролцогч болон сонирхогч талуудын судалгааг хөтөлбөр хэрэгжүүлэгч мэргэжлийн тэнхим л гүйцэтгэж байна, чанарын дотоод баталгаажуулалтын нэгжээс нэгдсэн судалгааг авах, тогтмолжуулах
- Бакалаврын төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх дунд шатны мэргэшүүлэх богино хугацаат сургалтуудыг зохион байгуулахад анхаарах

Зөвлөмж:

- Дотоод чанарын баталгаажуулалтыг хийхэд оролцогч болон сонирхогч талуудын судалгааг хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим нь өөрөө хийж байгаа нь хөндлөнгийн

үнэлгээ болж чадахгүй тул сургуулийн удирдлагууд бодлогын түвшинд туслалцаа үзүүлж, удирдлага зохион байгуулалтын оновчтой системийг хэрэгжүүлэх;

7.3. Үндэсний болон олон Улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон Улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон Улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Соёлын маркетингийн чиглэлээр төгсөгчид нь Монгол Улсын өнцөг булан бүрд үйл ажиллагаагаа явуулж буй соёл, урлагийн салбарын бүхий л байгууллагуудын удирдлагад нийт төгсөгчийн дийлэнх хэсэг нь ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Анхаарах асуудал:

- Соёл урлагийн Маркетингийн гадаадын улс орнуудын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгааг өргөн хүрээнд хийх, түүнээс туршлага судалж, олон улсын магадлан итгэмжлэлд системтэй бэлтгэх шаардлагатай.
- Төгсөгчдийн дотоодын болон гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах байдалд онцгой анхаарах

Шаардлага:

- Төгсөгчдийг дотоод, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулахад чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарах

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			
6	Багшийн үйл ажиллагаа	3	1		
7	Чанарын үнэлгээ баталгаажуулалт	1	2		
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Соёл Урлагийн Их сургуулийн Соёлын сургуулийн “Маркетинг” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: О.Бурмаа

Шинжээчийн багийн гишүүн: Л.Отгонцэцэг

Шинжээчийн багийн гишүүн: И.Баярсайхан

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Соёл Урлагийн Их Сургууль
Хөтөлбөрийн нэр	“Маркетинг” бакалаврын хөтөлбөр
Хөтөлбөрийн индекс	D041401
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> - Гадаад, дотоодын их сургуулиудын ижил төрлийн хөтөлбөрийг зөвхөн багц цагаар бус агуулгын хүрээнд харьцуулан судалж, хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах - Хөтөлбөрийн зорилгыг дахин тодорхойлохдоо мэргэжилтэн бэлтгэх талаас нь боловсруулах - Оролцогч болон сонирхогч талуудын судалгааг нэгдсэн арга зүйгээр боловсруулж, тогтмолжуулах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг зөвхөн мэдлэг, ур чадвараар (ерөнхий, мэргэжлийн) гаргасан байгааг шинэчлэн сайжруулах - Сургалтын арга зүйг хэрэгжүүлж буй байдлын гүйцэтгэлийг үнэлэх дүрэм, журмыг шинэчлэн сайжруулах - Суралцагчдыг үнэлэхэд СУИС-н дотоод журмыг баримтлан үнэлдэг боловч яг ямар үнэлгээний аргаар үнэлж буйг нарийвчлан тодорхойлох
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> - Орчин үеийн шинэлэг программ хангамжуудыг маркетингийн сургалтад нэвтрүүлэх - Мэргэжлийн болон мэргэшүүлэх суурь хичээлүүдэд ашиглаж буй программ хангамжийг албан ёсны лицензтэй болгон өргөжүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх - Гадаад номын захиалгын тоо болон нэгж номын тоо ширхгийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> - Олон Улсын стандартад нийцсэн боловсролын үйлчилгээг үзүүлж, соёлд суурилсан нийгмийг цогцлоох манлайлагчдыг бэлтгэдэг соёлын судалгааны их сургууль болох менежментийн тогтолцоог бүрдүүлэх - Төрийн болон төрийн бус байгууллагууд, гадаад дотоодын мэргэжлийн холбоод, уран бүтээлчид, хувийн сектортой хамтран ажиллах бодлого боловсруулж хэрэгжүүлэх - Санхүү, эдийн засгийн төлөвлөлт, төсөвлөлтийн уялдааг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэхийн тулд “хөрөнгө, эх үүсвэрийн удирдлагын оновчтой тогтолцоо”-г төлөвшүүлэх. - Санхүүгийн олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хамтран ажиллах соёлын байгууллагуудын нөөцийг ашиглах замаар хөрөнгө оруулах болон урсгал зардлуудыг бууруулах
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн зорилгын онцлогтой уялдуулан элсэгчдэд тавигдах шаардлагаа шинэчлэн сайжруулах - Суралцагчдын эрдэм шинжилгээний ажлыг хөхүүлэн дэмжих болон сайн дурын үйл ажиллагааг нэмэгдүүлэх
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Багш нарын гадаад хэлний мэдлэг, боловсролыг үр өгөөжтэй дээшлүүлэх, бодлогоор маркетинг хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийг англи хэл дээр заадаг болох хөтөлбөр хэрэгжүүлэх

	<ul style="list-style-type: none"> - Гадаад дотоодын их дээд сургуулиудтай багш солилцоог идэвхитэй хийх арга замыг эрэлхийлэх - Монголд Англи хэл дээр маркетингийн мэргэжлийн хичээл заадаг их дээд сургуулиуд бий, тэдний туршлагаас судалж, багш солилцоо, гэрээ хийж ажлуулах боломжийг эрэлхийлэх
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> - Оролцогч талуудын судалгааг сургуулийн хэмжээнд нэгтгэн гаргаж, тогтмолжуулах
ШААРДЛАГА	
Шалгуур 6.2 Багшийн хөгжил	<ul style="list-style-type: none"> - Соёлын сургууль, соёлын үйлдвэрлэлийн тэнхимийн “Академик нэр хүнд”-ийг дээшлүүлэх цогц төлөвлөгөө гаргаж ажиллах шаардлага тулгарч байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Гадаадын зочин профессор багш ажлуулах, гадаадын оюутан элсүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, - Гадаадын зочин профессор, гадаадын оюутан хүлээн авах бэлтгэл ажлын хүрээнд тэнхимийн багш нар багшийн хөгжлийн төлөвлөгөөндөө “ мэргэжлийн хичээлүүдээ Англи хэл дээр заах” бэлтгэл ажлуудыг тусгаж, өөрийгөө бэлтгэх шаардлагатай.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж сайжруулахдаа оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад хэр нийцэж байгааг судалж үнэлэлт, дүгнэлт өгөх - Дотоод чанарын баталгаажуулалтыг хийхэд оролцогч болон сонирхогч талуудын судалгааг хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим нь бус дотоод чанарын баталгаажуулалтын нэгж нь бие даан нэгдсэн арга зүйгээр гүйцэтгэдэг байх - Төгсөгчдийг дотоод, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулахад чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарах

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог, нэр	Албан тушаалын зэрэглэл	Эрдмийн цол, зэрэг	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Мөнхөө Гэрэлмаа	СС-ийн СҮТ-ийн эрхлэгч	Доктор (Ph.D), дэд проф.	11	Инновац, соёлын бүтээлч үйлдвэрлэл, Оюуны өмч, Хүний нөөцийн менежмент
2	Жүгдэрнамжил Эрхэмтөгс	СҮТ-ийн багш	Доктор (Ph.D), дэд проф.	24	Бүтээлч үйлдвэрлэлийн төсөл, Судалгаа шинжилгээний арга зүй
3	Нямдорж Содномдорж	СҮТ-ийн Ахлахбагш	Доктор (Sc.D), проф.	47	Хүний хөгжил, Макро эдийн засаг

4	Лхамсүрэн Тунгалаг	СҮТ-ийн Ахлахбагш	Магистр (МА)	38	Чөлөөт цагийн үйл ажиллагааны технологи
5	Шархүү Оюундэлгэрэх	СҮТ-ийн Ахлахбагш	Доктор (Ph.D)	24	Менежментийн үндэс, Байгууллагын зан төлөв
6	Галхүү Маралмаа	СҮТ-ийн Ахлах багш	Магистр (МА)	15	Соёл урлагийн менежмент, Эвент менежмент
7	Пүрэв Баасанжаргал	СҮТ-ийн ахлах багш	Магистр (МВА)	18	Маркетингийн үндэс, Маркетингийн судалгаа, шинжилгээ
8	Пүрэвжав Арвинбаяр	СҮТ-ийн ахлах багш	Магистр Магистр (МВА)	19	Санхүүгийн менежмент, Нягтлан бодох бүртгэл
9	Нямдорж Туул	СҮТ-ийн багш	Магистр (МА)	6	Дижитал маркетинг, Сошиал медиа маркетинг

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Н.Хажидсүрэн	IV	Орон нутаг	85138558
2	Э.Нямжав	IV	Дотуур байранд амьдардаг	89011135
3	Х.Алтангадас	IV	Голч өндөртэй	80073719
4	Б.Үйтүмэн	IV	Оюутны холбоонд ажилладаг	95500027
5	Байгалмаа	III	Улаанбаатар	85130666
6	Сарнай	III	Улаанбаатар	88277898
7	Уянга	III	Шилжиж ирсэн	95704444
8	Өнөрзаяа	III	Тэтгэлэг авсан	89353522
9	Э.Нарангарав	II	Улаанбаатар	80189840
10	М.Энхсарнай	II	Ажил хийдэг оюутан	88321224
11	М.Цогтбилэг	II	Оюутны дотуур байранд амьдардаг	86972019
12	Г.Тэмүүлэн	II	Орон нутаг	80507650
13	М.Мөнгөншагай	I	Голч өндөртэй	94247758
14	Б.Мөнх-Эрдэнэ	I	Улаанбаатар	95487078
15	Б.Даваажав	I	Улаанбаатар	85848486
16	Д.Сунжидмаа	I	Орон нутаг	95842005

III. Ажил олгогчдын нэрс

№	Ажил олгогчдын нэр	Албан байгууллага	Албан тушаал	Харилцах утас
1	Н.Өнөржаргал	ЦДБЭЧ	Маркетингийн албаны дарга	99026929
2	Дэлгэрмаа	Соёл, урлагийн хэрэгжүүлэгч агентлаг	Захиргаа удирдлагын хэлтсийн дарга	99013783
3	Н.Өлзийхишиг	Эрдэнэт үйлдвэр ТӨК “Уурхайчин соёлын ордон”	СУГ-ын дарга	88022931
4	Отгонбаатар	Говь-Алтай аймаг “Алтай” Чуулга	СУГ-ын дарга	89401239
5	Мөнхбаатар	УДЭТ менежер	Газрын дарга	91104449
6	Эрдэнэдэлгэр	Сүхбаатар аймаг СУГ	СУГ-ын дарга	
7	Жавхлан	“Уранган” ХХК	Захирал	
8	Мөнхсайхан	Төрийн бус байгууллагын төлөөлөл	Менежер	88004849
9	Тунгалаг	Төв аймгийн СУГ-ын дарга	менежер	99160475
10	Хулан	“ТЕСО”	СУГ-ын хэлтсийн дарга	92070073
11	Бүрэнтөгс	“Дуган хад” Жуулчны баз	Менежер	99382738
12	Н.Цэнд-Аюуш	Монголын залуучуудын холбоо	Төрийн бус байгууллагын тэргүүн	80666633
13	Цогзолмаа	Дундговь аймгийн СУГ-ын дарга	Продакшны үүсгэн байгуулагч	89116308, 91113608
14	Сайнгэрэл	Өмнөговь аймгийн СУГ	дарга	99929570
15	Баатарцогт	Хэнтий аймгийн СУГ	дарга	99600157

IV. Төгсөгчдийн нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Н.Хажидсүрэн	IV	Орон нутаг	85138558
2	Э.Нямжав	IV	Дотуур байранд амьдардаг	89011135
3	Х.Алтангадас	IV	Голч өндөртэй	80073719
4	Б.Үйтүмэн	IV	Оюутны холбоонд ажилладаг	95500027
5	Байгалмаа	III	Улаанбаатар	85130666
6	Сарнай	III	Улаанбаатар	88277898
7	Уянга	III	Шилжиж ирсэн	95704444
8	Өнөрзаяа	III	Тэтгэлэг авсан	89353522
9	Э.Нарангарав	II	Улаанбаатар	80189840
10	М.Энхсарнай	II	Ажил хийдэг оюутан	88321224
11	М.Цогтбилэг	II	Оюутны дотуур байранд амьдардаг	86972019
12	Г.Тэмүүлэн	II	Орон нутаг	80507650
13	М.Мөнгөншагай	I	Голч өндөртэй	94247758
14	Б.Мөнх-Эрдэнэ	I	Улаанбаатар	95487078
15	Б.Даваажав	I	Улаанбаатар	85848486
16	Д.Сүнжидмаа	I	Орон нутаг	958420005

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



Тус зөвлөлөөс ирүүлсэн Маркетинг хөтөлбөрийн шинжээчдийн тайлантай бид танилцлаа. Шинжээчдийн өгсөн санал, зөвлөмжийг бид цаашдын үйл ажиллагаандаа тусгаж, ажиллах болно.

Бидэнтэй хамтран ажилласан та бүхэнд баярлалаа.



Handwritten signature

Ш.ЭРДЭНЭЦЭЦЭГ

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/